



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Г Ажлын байрны тодорхойлолтод нэмэлт Г
өөрчлөлт оруулах ажлын хэсгийг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтэц, орон тоо шинээр батлагдсантай холбогдуулан ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Нямхорлоо Гал түймэртэй тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан Тэргүүн дэд дарга, дэд хурандаа,

Гишүүд:

Б.Мягмардорж Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, хошууч,

Д.Мөнхсайхан Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа,

Г.Нэргүй Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа,

Б.Баттулга Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа,

Д.Урантулга Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа,

Ж.Төмөрмандах Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч,

Д.Мөнхбат Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн менежер, дэд хурандаа,

Ж.Дамбадаржаа Нийслэлийн Аврах анги-105-ын Штабын дарга, ахмад,
Д.Одонбаяр Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Төрийн ордон болон тусгай объектуудыг Гамшгаас хамгаалах тасгийн дарга, ахлах байцаагч, хошууч,
Б.Мягмаржав Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, ахмад,
Э.Пүрэв-Очир Захиргааны удирдлагын хэлтсийн Хуулийн зөвлөх, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн,
Б.Бат-Очир Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн захирагч, дэд хурандаа,
С.Алтангэрэл Нийслэлийн Аврах анги-105-ын Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, дэслэгч,
Нарийн бичиг:
С.Содонтуяа Захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа,

2. Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын зөвлөлд 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

